



ТОГТВОРТОЙ УУЛ УУРХАЙН ТӨЛӨӨ



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

ХЯМРАЛЫН МЕНЕЖМЕНТ,
МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ
ТӨЛӨВЛӨЛТИЙН ПРОТОКОЛ



ТУУТ (TSM) СТАНДАРТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ПРОТОКОЛ ХЯМРАЛЫН МЕНЕЖМЕНТ, МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Зорилго

Энэхүү ТУУТ-н протоколын зорилго нь компанийн болон уурхайн байгууламжийн түвшний хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөлтийн үнэлгээнд дэмжлэг үзүүлэхэд оршино. Үүний хүрээнд хямралын менежмент, харилцаа холбооны төлөвлөгөө, төлөвлөгөөний тогтмол хяналт болон төлөвлөгөөний үр дүнтэй хэрэгжилтийг хангах тогтмол сургалтууд багтана. Энэхүү протоколын хэрэгжилтэд ТУУТ-н Хямралын менежмент ба мэдээлэл харилцааны лавлах гарын авлагад (TSM Crisis Management and Communications Reference Guide) тусгагдсан тодорхойлолт, чиглэл болон маягтууд мөн дэмжлэг болно.

Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

Дээрх зорилтуудын хүрээний гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор ТУУТ Хямралын менежмент, мэдээлэл харилцааны протокол нь гурван доорх үзүүлэлтэд хамаарах шалгууруудыг тогтоосон байдаг:

1. Бэлэн байдал
2. Хяналт
3. Сургалт

Компаниуд нь үзүүлэлт нэг бүрээр өөрийн гүйцэтгэлийг нийт компани болон ТУУТ стандартыг хэрэгжүүлж буй уурхайн байгууламж бүр дээр үнэлэх ёстой. ТУУТ стандартын бусад протоколоос ялгаатай нь эдгээр 3 үзүүлэлтийг Тийм/Үгүй гэсэн үнэлгээгээр тооцдог. Тодорхой нэг үзүүлэлтээр Тийм хэмээх рейтинг авахын тулд хамаарах бүхий л шалгуур үзүүлэлтийг ханган биелүүлсэн байх ёстой. Хэрэв шалгуур эсвэл үзүүлэлт нь үл хамаарах бол үнэлгээгээр Үл хамаарна (N/A) гэсэн үнэлгээг өгнө.

Менежментийн системд хийгддэг бусад үнэлгээний нэгэн адил үзүүлэлт нэг бүрийг, хамаарах шалгуур нэг бүрийг хангасан эсэх дээр мэргэжлийн дүн шинжилгээ, дүгнэлт хийхийг шаардана. Тиймээс энэхүү протоколыг баримтлахад аудит, системийн үнэлгээний чиглэлээрх мэдлэг, чадвар, мөн хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөлтийн практик дахь мэдлэг, туршлагыг, үүнд хамаарах зохицуулалтууд, тавигдаж буй шаардлагуудын талаарх мэдлэг, туршлагатай байхыг шаардана. Энэхүү протокол нь хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөлтийн хэрэгжилтийн үнэлэх арга хэрэглүүр юм. Харин протокол нь дангаараа тухайн үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг баталгаажуулахгүй ч эдгээр чиглэлд амжилт гаргахуйц мэдлэг, практик, компанийн соёлыг бүрдүүлэх зорилготой.

ҮЗҮҮЛЭЛТ 1: БЭЛЭН БАЙДАЛ

Зорилго

Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөтэй болохыг баталгаажуулах.

Компани: Бэлэн байдал

Үнэлгээний шалгуур:

Шалгуур
1. Гүйцэтгэх захирлын зүгээс хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг батлан, дэмжлэг үзүүлдэг байх. 2. Компанид учирч болох өндөр магадлалтай аюул, эрсдлүүдийг тодорхойлсон байх а. Эдгээр тодорхойлон гаргасан аюул, эрсдлүүдэд арга хэмжээ авах протоколтой байх. б. Компанийн төв оффис уурхайн байгууламжын тодорхойлсон аюул, эрсдлүүдийг судлан үзэж, эдгээрийг шаардлагатай тохиолдолд компанийн төлөвлөгөөнд тусгадаг байх. 3. Компанийн Хямралын менежментийн багийг үүсгэн байгуулж, чиг үүрэг болон хариуцлагыг тодорхойлон гаргасан байх. 4. Хямрал үүсэх тохиолдолд Компанийн хямралын менежментийн багийг ажиллуулж эхлэх зарлан мэдээлэх механизм бүрдсэн байх. 5. Сургалтад хамрагдсан эсвэл шаардлагатай мэдлэг, чадамж бүхий асуудлыг хариуцсан хэвлэлийн төлөөлөгчийг томилон ажиллуулсан байх. 6. Голлох хэвлэл мэдээлэл, холбоо барих этгээдийн мэдээллийг урьдчилан бэлтгэж, хэвлэл мэдээлэл болон оролцогч талуудтай харилцаж, оролцоог хангаж буй байдлыг хянах тогтолцоог бүрдүүлсэн байх. 7. Компанийн түвшний Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг боловсруулсан, энэхүү төлөвлөгөөг тогтмол хянадаг, шинэчилдэг байх. 8. Компанийн түвшний Хямралын менежментийн багийн бүх гишүүд нь Компанийн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөө, холбоо барих гол этгээдүүдийн мэдээллийг хүлээн авсан байх. 9. Хямралын хяналтын төвийг биетээр, цахимаар эсвэл хайбрид хэлбэрээр үүсгэн, шаардлага хангахуйц тоноглогсон байх. 10. Ажилтнуудад хямралын талаар зарлан мэдээлэх, шинэчилсэн мэдээлэл хүргэж байх мэдээлэл харилцааны механизмыг бүрдүүлсэн байх.

Уурхайн байгууламж: Бэлэн байдал

Үнэлгээний шалгуур:

Шалгуур	
1.	Уурхайн байгууламжид учрах боломжит аюул, эрсдлүүдийг тодорхойлон гаргасан байх. а. Эдгээр тодорхойлон гаргасан аюул, эрсдлүүдэд арга хэмжээ авах протоколтой байх б. Уурхай нь өөрийн тодорхойлсон аюул, эрсдэлүүдийн талаар компанийн төв оффист мэдээлэн харилцдаг байх.
2.	Уурхайн Хямралын менежментийн багийг байгуулан, чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байх.
3.	Хямрал гарах үед Уурхайн Хямралын менежментийн багийг ажиллуулах зарлан мэдээлэх механизм бүрдсэн байх.
4.	Хэвлэл мэдээлэлтэй харилцах этгээдийг томилж, сургалтад хамруулсан эсвэл тухайн этгээд нь шаардлагатай мэдлэг, чадвар, чадамжтай болохыг батлан харуулсан байх.
5.	Голлох хэвлэл мэдээлэл, оролцогч талуудын мэдээллийг бэлтгэж, хэвлэл мэдээлэл, оролцогч талуудтай харилцаж, татан оролцуулж буй үйл явцыг хянах тогтолцоог бүрдүүлсэн байх.
6.	Уурхайн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг боловсруулан гаргаж, энэхүү төлөвлөгөөг тогтмол хянадаг, шинэчилдэг байх.
7.	Уурхайн Хямралын менежментийн багийн бүх гишүүн нь уурхайн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөө болон голлох талуудтай холбоо барих мэдээллийг хүлээн авсан байх.
8.	Хямралын хяналтын төвийг биетээр, цахимаар эсвэл хайбрид хэлбэрээр үүсгэн, шаардлага хангахуйц тоноглогсон байх.
9.	Ажилтнуудад хямралын талаар зарлан мэдээлэх, шинэчилсэн мэдээлэл хүргэж байх мэдээлэл харилцааны механизмыг бүрдүүлсэн байх.
10.	Хамаарах Сонирхогч талуудад Уурхайн Хямралын менежментийн төлөвлөгөөнд оролцох боломжийг бүрдүүлсэн байх.
11.	Орон нутгийн онцгой байдлын албатай (хэрэв байгаа бол) жил тутамд уулзалт хийдэг байх.

Түгээмэл асуултууд: Компанийн үүрэг амлалт, эгэх хариуцлага, мэдээлэл харилцаа

#	Түгээмэл асуултууд
1	Хямрал гэж юу вэ?
2	Хяналттай баримт бичиг гэж юу вэ? What is controlled document ?
7	ТУУТ стандартыг хэрэгжүүлж буйгаас өөр улсад төв нь байрладаг компаниудын хувьд тухайн толгой компанийн Гүйцэтгэх захирал нь компанийн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг баталж, дэмжлэг үзүүлж буйгаа илтгэн харуулах шаардлагатай юу?

ҮЗҮҮЛЭЛТ 2: ХЯНАЛТ

Зорилго

Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөө нь компанийн хэрэгцээ, эрсдэлүүд болон үйл ажиллагаанд нийцсэн, хэрэгцээнд тохирсон байж, байнга хянагдаж, салбарын сайн туршлагыг тусган шинэчлэгдэж байдгийг баталгаажуулах.

Компани: Хяналт

Үнэлгээний шалгуур:

Шалгуур

1. Компанийн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг доорх тохиолдолд хянажх үзэхж, шинэчилдэг байх:
 - a. төлөвлөгөөний хэрэгжилтэд хамаарах хүний нөөцөд өөрчлөлт орсон,
 - b. бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт гарахад (жишээ нь шинэ уурхай нээх гэх мэт), болон/эсвэл
 - c. багадаа 2 жил тутамд.
2. Компанийн Хямралын менежментийн багт мэдэгдэх механизмыг багадаа жилд 2 удаа шалган тестлэх механизм бүрдсэн байх.
3. Голлох хэвлэл мэдээлэл, оролцогч талуудын мэдээллийг эргэн хянадаг эсвэл багадаа хоёр жил тутамд шинэчилдэг байх.
4. Хямралын талаар ажилчдад зарлан мэдэгдэх, шинэчлэн мэдээлэх механизмыг багадаа жил тутамд шалган тестэлдэг байх.
5. Компанийн Хямралын менежментийн багт шинэ гишүүд нэмэгдэхэд тухайн хугацаанаас хойш хоёр сарын дотор Компанийн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг танилцуулдаг үйл явц хэвшин тогтсон байх.

Уурхайн байгууламж: Хяналт

Үнэлгээний шалгуур:

Шалгуур

1. Уурхайн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг доорх тохиолдолд эргэн хянаж, шинэчилдэг байх:
 - a. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хамаарах хүний нөөцөд өөрчлөлт орсон,
 - b. Бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт гарахад (жишээ нь уурхайг өргөтгөх гэх мэт), болон/эсвэл
 - c. Багадаа 2 жил тутамд.
2. Уурхайн Хямралын менежментийн багт мэдэгдэх механизмыг багадаа жилд 2 удаа шалган тестлэх механизм бүрдэн тогтсон байх.
3. Голлох хэвлэл мэдээлэл, оролцогч талуудын мэдээллийг эргэн хянадаг эсвэл багадаа хоёр жил тутамд шинэчилдэг байх.
4. Хямралын талаар ажилчдад зарлан мэдэгдэх, шинэчлэн мэдээлэх механизмыг багадаа жил тутамд шалган тестэлдэг байх.
5. Уурхайн Хямралын менежментийн төлөвлөгөөг компанийн төв оффист гарган өгдөг байх.
6. Уурхайн Хямралын менежментийн багт шинэ гишүүд нэмэгдэхэд тухайн хугацаанаас хойш хоёр сарын дотор Уурхайн Хямралын менежментийн төлөвлөгөөг танилцуулдаг үйл явц хэвшин тогтсон байх.

ҮЗҮҮЛЭЛТ 3: СУРГАЛТ, УР ЧАДВАР

Зорилго

Хямралын менежментийн сургалт, ур чадварын хяналт, үүнд хямралын загварчилсан сургуулилт жил тутамд хийгдэж буйг баталгаажуулах.

Компани: Сургалт

Үнэлгээний шалгуур:

Шалгуур
1. Компанийн төв оффис жил тутамд хямралын загварчилсан (simulation) дасгал (tabletop) сургуулилт хийдэг байх.

Уурхайн байгууламж: Сургалт

Үнэлгээний шалгуур:

Шалгуур
1. Хямралын загварчилсан дасгал сургуулилтыг жил тутамд уурхайн түвшинд хийдэг байх.
2. Гурван жил тутамд хямралын иж бүрэн загварчилсан сургалт хийдэг байх.

Түгээмэл асуултууд: Сургалт

#	Түгээмэл асуултууд
3	“Хямралын загварчилсан ширээний дасгал сургуулилт” гэж юу вэ?
4	Хэрэв уурхай нь Хямралын менежмент, мэдээлэл харилцааны шинэ төлөвлөгөөтэй бол Үзүүлэлт 3 дээр А түвшнийг хангахын тулд Хямралын загварчилсан дасгал сургуулилтыг иж бүрнээр нь хийсэн байх шаардлагатай юу?
5	Бодит амьдрал дээр учирсан хямрал нь хямралын загварчилсан дасгал сургуулилт хийсэн байх ёстой гэсэн шаардлагыг хангах уу?
6	Хямралын загварчилсан дасгал сургуулилт нь бүхий л уурхайг хамарсан байх хэрэгтэй юу?

ХАВСРАЛТ 1: ТҮГЭЭМЭЛ АСУУЛТУУД

Түгээмэл асуултууд нь ТУУТ протоколын дагуу өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн баталгаажуулалтад заавал шаардагдах бүрэлдэхүүн хэсэг юм. Уурхайнууд нь протоколд тусгасан шалгууруудыг зөв тайлбарлан ойлгож, хэрэгжилтийг хангах зорилгоор доорх тодорхойлолт, зааварчилгааг судлан үзэж, даган мөрдөх нь зүйтэй.

1. Хямрал гэж юу вэ?

Хямрал гэж компани бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжийг хязгаарлахуйц гэнэтийн үүсэн гарч буй үйл явдал юм.

“Онцгой байдал” (Онцгой байдлыг хариу арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд уурхайн байгууламжийн удирдлага хариуцах) болон “хямрал” (Компанийн болон уурхайн түвшний ахлах удирдлагын оролцоо, арга хэмжээг шаардах) гэсэн ойлголтуудыг ялган салгах нь чухал.

Доорх нөхцөлд хямрал үүсэж эсвэл өрнөн тэлж болно:

- Онцгой байдал нь олон нийт, ажилтнуудад ноцтой хор, хохирол учруулах.
- Онцгой байдлаас үүдэн төрийн зүгээс хяналт шалгалт хийгдэх нөхцөл үүсэх.
- Компани нь тухайн нөхцөл байдлыг өөрийн хяналтдаа бүрэн байлгах боломжгүй болох (жишээ нь бусад байгууллага энэ үүргийг өөртөө авах).
- Нөхцөл байдал нь дотоод болон олон улсын хэвлэл мэдээллийн сонирхлыг татах.
- Нөхцөл байдал хүндрэх магадлалтай, шууд шийдэх арга зам бэлэн байхгүй.
- Компанийн нэр хүнд сэвтэх эсвэл хувьцааны үнэ эсвэл алдагдалд хүрэх.

Хямралын менежмент шаардагдаж болох хямралын нөхцөл байдлын жишээ:

- Үйлдвэрийн осол/ онцгой байдал. Жишээ нь осол гэмтэл эсвэл эд хөрөнгийн хохирол учруулах үйл явдал, гал түймэр, барилга нурах, уурхайд нуралт үүсэх, үер, дэлбэрэлт, эрчим хүчний саатал, хөлдөлт, ус алдалт гэх мэт.
- Байгалийн гамшиг. Жишээ нь үер, хөрсний гулгалт, хар салхи, далайн шуурга, газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт зэргээс болж хувь хүний аюулгүй байдал, бизнесийн үйл ажиллагаа эрсдэлд орох, тээвэрлэлтийн үйл ажиллагаа саатах, гамшигт өртсөн ард иргэдтэй холбоо харилцаа ноцтой хэмжээнд тасалдах үйл явдал.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ алслагдсан эсвэл хомс байдаг газрууд дахь эрүүл мэндийн онцгой байдал.
- Материал санамсаргүй асгах. Жишээ нь хаягдлын далан нурах, химийн бодис алдагдах зэрэг байгаль орчин болон өртсөн хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдалд томоохон сөрөг нөлөө үзүүлэхуйц үйл явдал.

- Хүн сураггүй алга болох.
- Улс төр, аюулгүй байдлын эрсдэл. Жишээ нь хун барьцаалах, айлган сүрдүүлэх, бөмбөг тэслэхээр сүрдүүлэх, бөмбөг дэлбэлэх, олон нийтийн эсвэл улс төрийн үймээн, эрх баригчдын зүгээс хууль бусаар баривчилгаа хийх, бослого эсвэл эсэргүүцлийн хөдөлгөөн.
- Ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид эсвэл орон нутгийн иргэдийн аюулгүй байдалд аюул учруулах эсвэл компанийн нэр хүндэд хохирол учруулахуйц, гэнэтийн бусад үйл явдал.

2. Хяналттай баримт бичиг гэж юу вэ? (Controlled document)

Хяналттай баримт бичиг гэж ажилтнуудад тухайн баримт бичгийн хамгийн сүүлийн хувилбар хүрч буйг баталгаажуулсан, даган мөшгөх (tracking) боломжтой баримт бичгийг хэлнэ. Энэ нь тухайн баримт бичгийг хянан тохиолдуулах, эргэн харах болон батлах, хуучирсан хувилбарыг устгах эсвэл буцаан татан, шинэ хувилбараар солих үйл явц хэвшиж тогтсон байна гэсэн үг юм. Үүний тулд гаргаж буй баримт бичгүүдийг хянаж байх үйл явц бүрдэж, үүний үр дүнд хамгийн сүүлийн хувилбар нь хүргэгдэж, өмнө хувилбараа шууд орлон хэрэгжиж байхыг шаардана.

Баримт бичгийн хяналтыг биет болон цахим баримт бичиг дээр хийж болно. Хяналттай цахим баримт бичгийн хувьд хяналтын үйл явц нь тухайн баримт бичгийн хэвлэн гаргах хүртэл үргэлжилнэ. Хэвлэн гаргаснаас хойш энэхүү баримт бичгийг хяналттай хэмээн тооцохгүй.

3. “Хямралын загварчилсан дасгал сургуулилт” гэж юу вэ? (Tablet-top crisis simulation)

Хямралын загварчилсан дасгал сургуулилт (table-top crisis simulation exercise) нь хямралын менежмент, мэдээлэл харилцааны ур чадварыг суулгах, Хямралын менежментийн багт өөрийн төлөвлөлтдөө буй сул талууд, хийдлийг олж тогтооход нь тусалдаг хэрэгцээтэй, хямд зардалтай арга хэрэгсэл.

Сургалтын чиглүүлэгч нь хямрал бодит амьдрал дээр болж буй юм шигээр үйл явдлыг дүрсэлж Хямралын менежментийн багийн гишүүдэд ямар нэгэн шийдвэр гарган, арга хэмжээ авахаас өмнө үүссэн нөхцөл байдлын талаар бүх төрлийн дүн шинжилгээ хийж, хэлэлцэхийг санал болгон энэхүү сургуулилт хийгдэнэ. Чиглүүлэгч нь хөндлөнгийн оролцогчийн үүднээс үүссэн хямрал, нөхцөл байдал, үүний ээдрээтэй байдал, давтамжуудыг улам нэмэгдүүлэх замаар сургуулилт хийгддэг.

Иж бүрэн хямралын загварчилсан сургуулилт зэрэг хямралын менежментийн янз бүрийн түвшний дасгал сургуулилтыг ТУУТ Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөлтийн лавлах зааварчилгааны 8 дугаар бүлэгт оруулсан. Мөн мэдээлэл харилцааны болон олон нийттэй харилцах чиглэлээр ажилладаг компаниуд хямралын менежмент, мэдээлэл харилцааны сургалтын үйлчилгээг санал болгодог.

4. Хэрэв уурхай нь Хямралын менежмент, мэдээлэл харилцааны шинэ төлөвлөгөөтэй бол Үзүүлэлт 3 дээр А түвшнийг хангахын тулд Хямралын загварчилсан дасгал сургуулилтыг иж бүрнээр нь хийсэн байх шаардлагатай юу?

Шинэ төлөвлөгөө гаргасанаас хойш уурхай нь хямралын иж бүрэн загварчилсан сургуулилтыг хоёр жилийн дотор төлөвлөн хийнэ. Хэрэв хямралын загварчилсан дасгал сургуулилтыг хийж шинэ төлөвлөгөөг шалган тестэлсэн буй бол үнэлгээчний зүгээс энэхүү үзүүлэлтэд “Тийм” гэсэн үнэлгээг өгч болно.

5. Бодит амьдрал дээр учирсан хямрал нь хямралын загварчилсан дасгал сургуулилт хийсэн байх шаардлагыг хангах уу?

Тийм, хэрэв хямрал болж, үүнийг зохицуулахдаа Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн бол бодит байдлыг тусгасан загварчилсан сургуулилт хийх шаардлагыг хангасан гэж үзэж болно. Хямралын дараагаар Хямралын менежментийн баг нь хуралдаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг эргэн харж, хянаж, сургамжууд болон төлөвлөгөөнд хийх шаардлагатай өөрчлөлтүүдийг тогтоосон байвал зохино. Энэхүү хяналтаас гарсан үр дүнг баримтжуулсан байвал зохино.

6. Хямралын загварчилсан дасгал сургуулилт нь бүхий л уурхайг хамарсан байх хэрэгтэй юу?

Үгүй, гэхдээ хямралын дасгал сургуулилт нь төрөл бүрийн нөхцөл байдал, уурхайн өөр өөр хэсгийг шалган тестэлсэн байх ёстой. Ингэснээр Хямралын менежмент, харилцаа холбооны төлөвлөгөөг тодорхой хугацааны дотор бүхий л хэсгүүдийг нь тестэлж, хянасан байна.

7. ТУУТ стандартыг хэрэгжүүлж буйгаас өөр улсад төв нь байрладаг компаниудын хувьд тухайн толгой компанийн Гүйцэтгэх захирал нь компанийн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөлтийг баталж, дэмжлэг үзүүлж буйгаа илтгэн харуулах шаардлагатай юу?

Компанийн төв (олон улс дахь), оффис болон Гүйцэтгэх захирлын зүгээс тухайн улсаас бусад, энэхүү протокол хэрэгжиж буй улсад буй өөрийн компанийн хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөлтийг дэмжиж буйгаа илэрхийлэх эсвэл эцэслэн баталсан байх шаардлагагүй. Энэ тохиолдолд тухайн улс дахь хамгийн дээд удирдах албан тушаалтан төлөвлөгөөг баталж, дэмжин хэрэгжүүлж байх шаардлагатай.

ХАВСРАЛТ 2: ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГАХ ХУУДАС

Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөө –
Компанийн түвшинд

Уурхайн байгууламжийн нэр:		Компанийн нэр:	
Үнэлгээ хийсэн хүний нэр:		Хүргүүлсэн огноо:	

Дэмжих баримт бичиг/ Нотолгоо:	
Баримт бичгийн нэр	Байршил

Ярилцлагад хамрагдсан хүмүүс:			
Нэр	Албан тушаал	Нэр	Албан тушаал

	АСУУЛТ	Тийм	Үгүй	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 1: Компанийн түвшний хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөө				
Үзүүлэлт 1 – Компани	1. Гүйцэтгэх захирлын зүгээс хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг батлан, дэмжлэг үзүүлдэг үү?			
	2. Компанид учирч болох өндөр магадлалтай аюул, эрсдэлүүдийг тодорхойлсон уу?			
	a. Эдгээр тодорхойлон гаргасан аюул, эрсдэлүүдэд арга хэмжээ авах протоколыг бүрдүүлсэн үү?			
	b. Компанийн төв оффис нь уурхайн байгууламжийн тодорхойлсон аюул, эрсдэлүүдийг судлан үзэж, эдгээрийг шаардлагатай тохиолдолд компанийн төлөвлөгөөнд тусгадаг уу?			
	3. Компанийн Хямралын менежментийн багийг байгуулж, чиг үүрэг болон хариуцлагыг тодорхойлон гаргасан уу?			
	4. Хямралын нөхцөл үүсэх тохиолдолд Компанийн хямралын менежментийн багийг ажиллуулж эхлэх зарлан мэдээлэх механизм бүрдсэн үү?			
	5. Шаардлагатай сургалтад хамрагдсан эсвэл зохих мэдлэг, чадамж бүхий асуудлыг хариуцсан хэвлэлийн төлөөлөгчийг томилон ажиллуулж байна уу?			
	6. Голлох хэвлэл мэдээлэл, холбоо барих этгээдийн мэдээллийг бэлтгэж, хэвлэл мэдээлэл болон оролцогч талуудтай харилцах харилцааг хянах тогтолцоо бүрдүүлсэн үү?			
	7. Компанийн хэмжээний Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг боловсруулсан, энэ нь хяналттай баримт бичиг үү?			

Үзүүлэлт 1 – Компани	8. Компанийн түвшний Хямралын менежментийн багийн бүх гишүүд нь Компанийн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөө, холбоо барих гол этгээдүүдийн мэдээллийг хүлээн авсан байна уу?			
	9. Хямралын хяналтын төвийг биетээр, цахимаар эсвэл хайбрид хэлбэрээр үүсгэн, шаардлагатай хэмжээнд тоноглосон байна уу?			
	10. Ажилтнуудад хямралын талаар зарлан мэдээлэх, шинэчилсэн мэдээлэл хүргэж байх мэдээлэл харилцааны механизмыг бүрдүүлсэн байна уу?			
	<i>Хэрэв бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол энэхүү үзүүлэлт дээр “Тийм” гэж хариулна. Эс бөгөөс “Үгүй” хэмээх хариултыг өгнө.</i>			
	КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 1 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ	Тийм / Үгүй: _____		

	АСУУЛТ	Тийм	Үгүй	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 2: Компанийн хяналт				
I Үзүүлэлт 2 – Компани	1. 1. Компанийн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг доорх тохиолдолд хянан үзэж, шинэчилдэг үү?			
	a. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хамаарах хүний нөөцөд өөрчлөлт гарсан тохиолдолд?			
	b. Бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт гарахад (жишээ нь шинэ уурхай нээх гэх мэт)?, БОЛОН/ЭСВЭЛ			
	c. Багадаа 2 жил тутамд?			
	2. Компанийн Хямралын менежментийн багт мэдэгдэх механизмыг багадаа жилд 2 удаа шалган тестлэх механизм бүрдсэн үү?			
	3. Голлох хэвлэл мэдээлэл, оролцогч талуудын холбоо барих мэдээллийг эргэн хянадаг эсвэл багадаа хоёр жил тутамд шинэчилдэг үү?			

I Үзүүлэлт 2 – Компани	4. Хямралын талаар ажилчдад зарлан мэдэгдэх, шинэчлэн мэдээлэх механизмыг багадаа жил тутамд шалган тестэлдэг үү?			
	5. Компанийн Хямралын менежментийн багт шинэ гишүүд нэмэгдэхэд тухайн хугацаанаас хойш хоёр сарын дотор Компанийн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг танилцуулдаг үйл явц хэвшин тогтсон уу?			
	<i>Хэрэв бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол энэхүү үзүүлэлт дээр “Тийм” гэж хариулна. Эс бөгөөс “Үгүй” хэмээх хариултыг өгнө.</i>			
	КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ	Тийм / Үгүй: _____		

	АСУУЛТ	Тийм	Үгүй	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 3: Компанийн сургалт				
I Үзүүлэлт 3 – Компани	1. Компанийн төв оффист жил тутамд хямралын загварчилсан (simulation) дасгал (tabletop) сургуулилт хийдэг үү?			
	<i>Хэрэв бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол энэхүү үзүүлэлт дээр “Тийм” гэж хариулна. Эс бөгөөс “Үгүй” хэмээх хариултыг өгнө.</i>			
	КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 3 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ	Тийм / Үгүй: _____		

Хямралын менежмент болон мэдээлэл харилцааны төлөвлөлт – Уурхайн байгууламжийн түвшин

Уурхайн нэр:		Компанийн нэр:	
Үнэлгээ хийсэн ажилтаны нэр :		Хүргүүлсэн огноо:	

Дэмжих баримт бичиг/ Нотолгоо:	
Баримт бичгийн нэр	Байршил

Ярилцлагад хамрагдсан хүмүүс:			
Нэр	Албан тушаал	Нэр	Албан тушаал

	АСУУЛТ	Тийм	Үгүй	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 1: Уурхайн байгууламжын Хямралын менежмент болон мэдээлэл харилцааны бэлэн байдал				
Үзүүлэлт 1 – Уурхайн байгууламж	1. Уурхайд учрах боломжит аюул, эрсдэлүүдийг тодорхойлон гаргасан уу?			
	а. Тодорхойлон гаргасан аюул, эрсдэлүүдэд арга хэмжээ авах протоколыг гаргасан уу?			
	б. Уурхайн нь тухайн тодорхойлсон аюул, эрсдэлүүдийн талаар компанийн төв оффист мэдээлэн харилцдаг уу?			
	2. Уурхайн Хямралын менежментийн багийг байгуулан, үүний роль, чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлсон уу?			
	3. Хямрал тохиох үед Уурхайн Хямралын менежментийн багийг ажиллуулах зарлан мэдээлэх механизм бүрдсэн үү?			

Үзүүлэлт 1 – Уурхайн байгууламж	4. Хэвлэл мэдээлэлтэй харилцах этгээдийг томилж, сургалтад хамруулсан эсвэл тухайн ажилтан нь шаардлага хангахуйц мэдлэг, чадвар, чадамжтай болохыг илтгэн харуулсан уу?			
	5. Голлох хэвлэл мэдээлэл, оролцогч талуудын мэдээллийг бэлтгэж, хэвлэл мэдээлэл, оролцогч талуудтай харилцаж, татан оролцуулж буйг хянах тогтолцоо бүрдүүлсэн үү?			
	6. Уурхайн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг боловсруулан гаргаж, энэ нь хяналттай баримт бичиг байна уу?			
	7. Уурхайн Хямралын менежментийн багийн бүх гишүүн нь уурхайн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөө болон голлох талуудтай холбоо барих мэдээллийг хүлээн авсан уу?			
	8. Хямралын хяналтын төвийг биетээр, цахимаар эсвэл хайбрид хэлбэрээр үүсгэн, шаардлагатай хэмжээнд тоноглогсон уу?			
	9. Ажилтнуудад хямралын талаар зарлан мэдээлэх, шинэчилсэн мэдээлэл хүргэж байх мэдээлэл харилцааны механизмыг бүрдүүлсэн үү?			
	10. Хамаарах Сонирхогч талуудын Уурхайн Хямралын менежментийн төлөвлөгөөнд оролцох боломжийг бүрдүүлсэн үү?			
	11. Орон нутгийн онцгой байдлын албатай (хэрэв байгаа бол) жил тутамд уулзалт хийдэг үү?			
<i>Хэрэв бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол энэхүү үзүүлэлт дээр “Тийм” гэж хариулна. Эс бөгөөс “Үгүй” хэмээх хариултыг өгнө.</i>				
		Тийм	Үгүй	Тайлбар ба нотолгоо
	УУРХАЙН БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 1 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ	Тийм / Үгүй: _____		

АСУУЛТ		Тийм	Үгүй	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 2: Уурхайн байгууламж дээрх хяналт				
Үзүүлэлт 2 – Уурхайн байгууламж	1. 1. Уурхайн Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөгөөг доорх тохиолдолд эргэн хянаж, шинэчилдэг үү?			
	a. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хамаарах хүний нөөцөд өөрчлөлт гарсан үед?			
	b. Бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт гарах үед (жишээ нь уурхайг өргөтгөх гэх мэт)?, БОЛОН/ ЭСВЭЛ			
	c. Багадаа 2 жил тутамд?			
	2. Уурхайн Хямралын менежментийн багт мэдэгдэх механизмыг багадаа жилд 2 удаа шалган тестлэдэг үү?			
	3. Голлох хэвлэл мэдээлэл, оролцогч талуудын мэдээллийг эргэн хянадаг эсвэл багадаа хоёр жил тутамд шинэчилдэг үү?			
	4. Хямралын талаар ажилчдад зарлан мэдэгдэх, шинэчлэн мэдээлэх механизмыг багадаа жил тутамд шалган тестэлдэг үү?			
	5. Уурхайн Хямралын менежментийн төлөвлөгөөг компанийн төв оффист гарган өгдөг үү?			
	6. Уурхайн Хямралын менежментийн багт шинэ гишүүд нэмэгдэхэд тухайн хугацаанаас хойш хоёр сарын дотор Уурхайн Хямралын менежментийн төлөвлөгөөг танилцуулдаг үйл явц хэвшин тогтсон уу?			
Хэрэв бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол энэхүү үзүүлэлт дээр “Тийм” гэж хариулна. Эс бөгөөс “Үгүй” хэмээх хариултыг өгнө.				
УУРХАЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ		Тийм / Үгүй: _____		

	АСУУЛТ	Тийм	Үгүй	Тайлбар ба нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 3: Уурхайн байгууламж дээрх сургалт				
Үзүүлэлт 3 – Уурхайн байгууламж	1. Уурхай дээр жил тутамд хямралын загварчилсан (simulation) дасгал (tabletop) сургуулилт хийгддэг үү?			
	2. Гурван жил тутамд хямралын иж бүрэн загварчилсан сургалт хийгддэг үү?			
	Хэрэв бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол энэхүү үзүүлэлт дээр “Тийм” гэж хариулна. Эс бөгөөс “Үгүй” хэмээх хариултыг өгнө.			
	УУРХАЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 3 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ	Тийм / Үгүй: _____		



**ТОГТВОРТОЙ
УУЛ УУРХАЙН
ТӨЛӨӨ**

Хямралын менежмент, мэдээлэл харилцааны төлөвлөлтийн протокол

ТУУТ санаачилгын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл:

www.TSMInitiative.com

эсвэл

Канадын Уул Уурхайн Ассоциаци

www.mining.ca/tsm

Энэхүү нийтлэлийг боловсрол болон ашгийн бус бусад зорилгоор Канадын Уул Уурхайн Ассоциацийн урьдчилсан бичгийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлахыг зөвшөөрнө. Гэхдээ эх сурвалжийг бүрэн дурдсан байх шаардлагатай.

Энэхүү нийтлэлийг борлуулах болон бусад арилжааны зориулалтаар хуулбарлахыг Канадын Уул Уурхайн Ассоциацийн урьдчилсан бичгийн зөвшөөрөлгүйгээр хориглоно.

©2021 Канадын Уул Уурхайн Ассоциаци. Towards Sustainable Mining®, TSM®, зэрэг барааны тэмдгүүд нь Канад эсвэл бусад улс орнуудад Канадын Уул Уурхайн Ассоциацийн бүртгэлтэй эсвэл бүртгэлгүй барааны тэмдэг болно.



**МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ**

 www.miningmongolia.mn

 Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци

 Mongolian National Mining Association

 @miningmongolia

 @mongolian_mining_association

 Info@miningmongolia.mn

 +976 7011 0163